



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 8/12

Модот

**Т.Төрболдод сахилгын шийтгэл
ногдуулах тухай**

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Шадар сайдын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр тус суманд зохион байгуулагдсан уг гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийн үеэр жижүүр, сантехникч албан тушаалтай Т.Төрболд нь архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн байсан тул өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр хаалттай сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Албан үүргээ холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд биелүүлж, дахин дутагдал гаргахгүй ажиллахыг жижүүр, сантехникч Т.Төрболдод үүрэг болгосугай.

3. Тушаалыг ажилтаны хувийн хэрэгт хавсарган биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сургуулийн нийгмийн ажилтан (Б.Адъяахүү)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Д.ОТГОНДУЛАМ